

“ИТГЭЛТ СТӨВНӨ”ХХК

3760863 Сэлэнгэ аймаг, Мандал сум

Утас: +976 88106604

И-мэйл: batushka_bya@yahoo.com

2025. 10.28 № 07/10.
танай _____ № _____

**БАЙГАЛЬ ОРЧИН, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН ЯАМНЫ
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ, АУДИТЫН ХЭЛТЭС-д**

Хүсэлт гаргах тухай

Манай төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан 2022 онд батлагдсан бөгөөд 2022, 2023 онд үйл ажиллагаа явуулаагүй тухай Мандал сумын Засаг даргын тодорхойлолт, 2024 онд Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг батлуулж, биелэлтийг дүгнүүлээгүй ажилласан учир 0890143 дугаартай шийтгэл /1,000,000 төг/-ийн хүүдас тус тус хавсаргасан.

5 жилийн БОМТ-ний зардал **192,394 мян.төг** боловч Эрдэнэтолгойн өвөр дайрганы ордын нөөцийн тооцоо, уурхайн ТЭЗҮ-д тусгаснаар 27 жилийн турш уурхайн ашиглалт олборлолт явагдах ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ашиглалтын 24 дэх жилд хийхээр төлөвлөсөн байгаа нь эхний 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээлтээр хийгдэх ажил тусгагдахгүй. Иймд нөхөн сэргээлтийн зардал **152,064.0** мян.төгрөгийг хасаж 5 жилийн БОМТ-ний зардал **50,430 мян.төг** байна.

Дээрх зардалтай үялдуулан 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 9,581,500 төгрөгийн ажлыг тусган, Мандал сумын Байгаль орчин нөхөн сэргээх санд 4,790,750 төгрөгийг байршуулсан.

Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан хийгдэж байх үед бид засварын газар байгуулахаар төлөвлөж байсан ч байгуулагдаагүй тул засварын газартай холбоотой ажлуудыг хасаж Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулсан.

Иймд манай төслийн 2025 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг баталж өгнө үү.

Захирал



Б.Батбаатар

ГАРЧИГ

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА.....	2
ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	12
ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	16
ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ.....	17
ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ	18
НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	19
ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ.....	20
АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР.....	24
АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	25
АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ	26
ТАВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ	27

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Төсөл хэрэгжүүлэгч аж ахуйн нэгж, байгууллагын нэр, хаяг

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Итгэлт Стөвнө” ХХК

Регистрийн дугаар: 3780863


Улсын бүртгэлийн дугаар: 1311015074

Сэлэнгэ аймаг, Мандал сум 2-р баг, Ширхэнцэг, сббхк, 6, 150 тоот. Утас: 88106604

Төслийн байршил:

Төсөл хэрэгжих газар нь Сэлэнгэ аймгийн Мандал сумын /6-р/ багийн нутагт 25.56 га талбай оршино. Төслийн талбайн булангийн цэгүүдийн солбицлыг дараах хүснэгтээр харууллаа.

Тусгай зөвшөөрөл №	Олгогдсон (он-сар-өдөр)	Хугацаа (жил)	Цэгийн дугаар	Уртраг (град, мин, сек)	Өргөрөг (град, мин, сек)
MV -43000249 /СЭ-0004А/ (25.56 га)	2021-07-05	15	1	106° 32' 03.1"	48° 51' 58.2"
			2	106° 32' 11.1"	48° 52' 14.5"
			3	106° 32' 33.9"	48° 52' 10.9"
			4	106° 32' 25.3"	48° 51' 53.9"



Зураг 1. MV -43000249 /СЭ-0004А/ тоот тусгай зөвшөөрөлтэй талбайн байрлал



Зураг 2. Уурхайн харагдах байдал



Зураг 3. Бутлах ангилах цех

Төслийн хүчин чадал

Үйлдвэрлэлийн нөөц 12456.22 мян.тн дайрга ба жилийн 150.0 мян.тн хүчин чадалтайгаар 83 жилийн хугацаанд олборлоно. 2020 оны 12-р сарын 18-нд хайгуулын орд нөөцийг Уул Уурхай Хүнд Үйлдвэрийн Яам-аар батлуулж 30 жилийн хугацаанд 12 сая тонн нөөцтэй гэж тогтоолгосон.

Хүснэгт 1. Уурхайн календарчилсан төлөвлөгөө

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Ашиглах жилүүд						Нийт
			1	2	3	4	5	6-20	
1	Дайрга	мян.м³	150	150	150	150	150	3311.81	4665.25
2	Хөрс	мян.м³	3.9	4.2	4.2	3.6	3.8	113.8	124.92
3	Уулын цул	мян.м³	153.9	154.2	154.2	153.6	153.8	3425.6	4790.17
4	Хөрс хуулалтын итгэлцүүр	м³/м³	0.03	0.03	0.03	0.02	0.03	0.03	0.03

Хүснэгт 2. Үйлдвэрлэлийн нөөцийн тооцоо

Геологийн нөөц		Уурхайн хүрээн дэх нөөц	Ашиглалтын нөөц				
Нөөцийн блокийн дугаар ба нөөцийн зэрэг	Ашигт малтмалын нөөц, тн		Хаягдал, %	Хаягдал, м³	Бохирдол, %	Бохирдол, мян.м³	Ашиглалтын нөөц, тн
В-I	4012191.6	4012191.6	0.05	2006.1	0		4010185.5
В-II	3878734.1	3878734.1	0.05	1939.4	0		3876794.7
В-III	4272117.2	4272117.2	0.05	2136.0	0		4269981.2
Бодитой (В) нөөц бүгд	12163042.9	12163042.9	0.05	6081.5	0		12156961.4

Хүснэгт 3. Уурхайн ажиллах горим

№	Үзүүлэлт	Хэмжээс
1	Хоног дахь ээлжийн тоо	2
2	Ээлжийн үргэлжлэх хугацаа, цаг	12
3	Ээлж дэх амралт, сул зогсолт, цаг	2
4	Ажиллах цаг	10
5	Баяр ёслол, цаг агаарын саатал, хоног	5
6	Жилд ажиллах хоног	205

Уулын ажлын механикжуулалт, тоног төхөөрөмж

Ил уурхайн үйл ажиллагаа нь шимт хөрсийг хуулах-овоолох, дайргад өрөмдлөг тэсэлгээ хийн ухаж ачих, тээвэрлэн бутлан ангилах цехийн талбайд асгах, түр овоолгод овоолох гэсэн үндсэн процессоор явагдана.

Хүснэгт 4. Уулын ажлын механикжуулалт

Технологи	Үндсэн ажил	Технологийн процессууд
Авто тээвэртэй ашиглалтын технологи	Хөрс хуулалт	Ухаж ачих Тээвэрлэх Овоолгод хураах
	Олборлолт	Өрөмдлөг тэсэлгээ Ухах Ачих Тээвэрлэх Бутлах төхөөрөмжийн бункерт асгах

Өрөмдлөгийн ажил

Ордын чулуулгийн физик механикийн шинж чанарыг үндэслэн чулуулгийн бат бөхийн коэффициентыг Г=8-10-аар/Проф.Протоdjяконовын ангиллаар/ тооцов. Иймээс уурхайн дайрганд өрөмдлөг тэсэлгээний ажил хийх шаардлагатай. Хөрсний зузаан нь 0.5м газрын гадаргууд байх учир хөрсөнд

өрөмдлөг тэсэлгээ хийгдэхгүй. Хучаас хурдсын физик-механик шинжчанаарыг үндэслэн тус ордыгдунд өрөмдөгдөх ($P_0=5.1-10$) зэрэглэлд хамруулав.

Чулуулгийн дундаж бутлагдлын хэмжээг ажиллах экскаваторын утгуурын багтаамжаас хамааруулан тооцов.

$$d_a = (0.15 - 0.2) \cdot \sqrt[3]{E} \quad ; \text{ м}$$

Эрдэнэтолгойн өвөр нэртэй барилгын чулууны ордын өрөмдлөгийн ажилд БНХАУ- д үйлдвэрлэсэн Hanfa HF-115Y загварын өрмийн машиныг ашиглана.

Тэсэлгээний ажил

Орд нь гидрогеологийн хувьд ашиглахад хүндрэл багатай ордод хамаарна. Иймд дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат "Анфо" болон "Эмульс"-ийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ.

Тэсэлгээний ажлыг уул уурхайн өрөмдлөг тэсэлгээний чиглэлээр дагнан үйл ажиллагаа явуулдаг, тэсэлгээний ажил үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий компаниар хийлгэнэ. Тэсрэх бодис, тэсэлгээний хэрэгслийг тэсрэх бодисын үйлдвэрээс холбогдох хууль тогтоомжийн дагуу тусгай зориулалтын тээврийн хэрэгслээр уурхайн нэг удаагийн тэсэлгээнд шаардлагатай тэсрэх бодис, материалыг тээвэрлэн авчирч тэсэлгээг хийнэ. Тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөл бүхий тэсэлгээний инженерүүд хариуцан гүйцэтгэнэ.

Хүснэгт 5. Тэсэлгээний аюултай бүс

№		Үзүүлэлт		Хэмжээ
1	W_H	Шидэлтийн аюултай зайн итгэлцүүрфицент		3.04
2	$R_{шх}$	Шидэлт хүнд үйлчлэх	м	300.0
3	$R_{шт}$	Шидэлт тоног төхөөрөмжид үйлчлэх	м	150.0
4	$R_{цх}$	Агаарын цохилтын долгион хүнд үйлчлэх	м	285.28
5	$R_{цб}$	Агаарын цохилтын долгион барилга байгууламжид үйлчлэх	м	233.41
6	$R_ч$	Чичиргээ төхөөрөмжид үйлчлэх	м	84.03

Хүснэгт 6. Нэг удаагийн тэсэлгээний хэрэгсэл, тэсрэх бодисын зарцуулалт

№	Тэсэлгээний хэрэгсэл, нэг удаагийн тэсэлгээнд	Х.н	1 жил
1	Цооногийн цэнэг өдөөгч (booster)	кг	399
2	Искра, 6м	шир	435.6
3	Нонель хором удаашруулагч	шир	399
4	Цочир дамжуулах шижим	м	1111
5	Гал дамжуулах шижим	м	235
6	Нонель	шир	2
7	Хавчаар	шир	363
8	Нэг удаагийн тэсэлгээнд орох тэсрэх бодис	тн	15

Хүснэгт 7. Жилд хэрэглэх тэсэлгээний хэрэгсэл, тэсрэх бодисын зарцуулалт

№	Тэсэлгээний хэрэгсэл, нэг удаагийн тэсэлгээнд	Х.н	Хэмжээ
1	Цооногийн цэнэг өдөөгч (booster)	кг	2793
2	Искра, 6м	шир	3049
3	Нонель хором удаашруулагч	шир	2793
4	Цочир дамжуулах шижим	м	7779
5	Гал дамжуулах шижим	м	1647
6	Нонель	шир	14
7	Хавчаар	шир	2541
8	Нэг удаагийн тэсэлгээнд орох тэсрэх бодис	тн	103

Ухаж, ачих процесс

Уурхайн хөрс хуулалт, дайрга олборлолтын ажилд дараах тоног төхөөрөмжийн хослол ажиллана.

Хүснэгт 8. Экскаваторын техникийн тодорхойлолт

№	Үзүүлэлтүүд	Хэмжих нэгж	Хөрс, дайрга
			R300LC
1	Утгуурын багтаамж	м³	1.5
2	Утгалтын түвшин дэх хамгийн их радиус	м	10.28
3	Утгалтын хамгийн их өндөр	м	10.84
4	Утгалтын хамгийн их гүн	м	6.44
5	Утгалтын хамгийн их радиус	м	11.97
6	Ачилтын хамгийн их өндөр	м	6.94
7	Арын эргэлтийн радиус	м	4.38
8	Хөдөлгүүрийн чадал	кВт	168
9	Явах хурд	км/цаг	4.1
10	Масс	тн	33.9
11	Түлшний савны багтаамж	л	670
12	Үндсэн хэмжээснүүд	м	
12.1	Урт	м	4.94
12.2	Гадна өргөн	м	2.99
12.3	Өндөр	м	3.01

Уурхайн тээвэрлэх процесс

Уурхайн хөрс хуулалт, дайрга олборлолтод ашиглах автосамосвалууд нь ил уурхайгаас хуулах хөрс болон олборлох дайргыг уурхайн гол замаар тээвэрлэж хөрсийг хөрсний гадаад овоолго, дайргыг баяжуулах үйлдвэрийн бункерт шууд асгах эсвэл хүдрийн агуулах (түр овоолго) хүртэл тээвэрлэнэ. Дотоод тээвэрт БНХАУ-д үйлдвэрлэсэн HOWO-3257 маркийн 20 тн даацтай автосамосвал ажиллана.

Хүснэгт 9. Тээвэрлэлт хийх автосамосвалын техникийн үзүүлэлт

№	Үзүүлэлт	Хэмжих нэгж	Утга
1	Автосамосвал		HOWO-ZZ3257
2	Даац	тн	20
3	Өөрийн масс	тн	12.3
4	Тэвшний багтаамж	м³	12
5	Дээд хурд	км/цаг	80
6	Хөдөлгүүрийн заасан чадал	морь/хүч	260
7	Эргэлтийн радиус	м	10.2
8	Тэвшний өргөн	м	2.49
9	Урт	м	9.9
10	Өргөн	м	2.5
11	Өндөр	м	3.2
12	Дугуйн томъёо	-	6x4
13	Дугуйн хэмжээ	-	12.0R20
14	Түлшний савны багтаамж	л	200
15	Дугуйн тоо	ш	10

Овоолох процесс

Эрдэнэтолгойн өвөр нэртэй барилгын чулууны орд нь уулын бэл орчимд газрын гадаргад 0.5 м зузаантай хөрстэй. Жилд хуулах хөрсний хэмжээ 4 мян.м³ байгаа тул хөрс хуулалтад бульдозер худалдаж авах шаардлагагүй, экскаватор автосамосвалын хослолоор өнгөн хөрсийг хуулж тусад нь овоолохоор төсөлд тусгасан байна. Эхний 5 жилийн төлөвлөгөөгөөр ордын зүүн хэсгээс олборлох тул өнгөн хөрсний овоолгыг талбайн баруун хэсэгт түр овоолно.


Ордын нөөцийг тусгай зөвшөөрлийн талбайн хүрээгээр бодсон тул үйлдвэрийг төсөл хэрэгжүүлэгч Сэлэнгэ аймгийн Мандал сумаас газар ашиглахаар авсан ордын урд хэсэгт байрлах газар барина. Дайргыг шууд баяжуулах үйлдвэрийн бункерт буулгах нь дахиж ачих зардлыг хэмнэнэ.

Хүснэгт 10. Овоолгын хэмжээснүүд

Ашиглалтын жилүүд	Овоолгын эзлэхүүн, мян.м ³	Сийрэгжилт тооцооноор, мян.м ³	Овоолгын талбай, га	Овоолгын хамгийн их өндөр, м	Овоолгын өндөршилт	Овоолгын төв цэгийн солбицол
Өнгөн хөрсний гадаад овоолго						
1 дэх жил	4.16	4.99	0.17	3	955	48°52' 1.32" 106° 32'4.38"
2 дахь жил	4.35	5.22	0.17	3	955	
3 дахь жил	4.02	4.82	0.16	3	955	
4 дэх жил	3.96	4.75	0.16	3	955	
5 дахь жил	3.94	4.73	0.16	3	955	
Нийт	20.42	24.5	0.82	3	955	

Бутлан ангилах технологи

Уурхайн тэсэлгээний ажлын тооцоонд тэслэгдсэн чулуулгийн дундаж бутлагдлын хэмжээг 366 мм гэж тооцоолсон байгаа бөгөөд /өрмийн машин сонголтын тооцоонд/ уурхайн бутлан ангилах цехийн хүлээн авах бункерт хамгийн ихдээ 400 мм дайрга хүлээн авахаар тооцоолсон байна. Хүлээн авах бункерийн амсар дээр 400 мм нүхтэй гүлдмай шигшүүр байрлуулах бөгөөд торны нүхээр нэвтэрсэн /-400 мм/ том ширхэглэлтэй уулын чулууг хацарт бутлуурт бутлан туузан дамжуулгын тусламжтайгаар чичиргээт шигшүүрээр оруулах ба -20 мм-ээс доош ширхэглэлтэй дайрга шууд эцсийн 3 шатны бүтээгдэхүүн болон гарна. Харин +20 мм-ээс дээш ширхэглэлтэй дайргыг 2-р шатны цохилтот бутлуур РУУ оруулна. Цохилтот бутлуурт бутлагдсан дайрга буцаад чичиргээт шигшүүрээр шигшигдэн 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм ангилалын фракц болон ангилагдана. Ордын чулуулгийн шинж чанар, ширхэглэлийн бүрэлдэхүүн зэргээс хамааран Зураг 14-д үзүүлсэн схемийг сонголоо.




Зураг 4. Дайрга бутлан ангилах технологийн схем

Дайрга бутлан ангилах цехийн тоног төхөөрөмж

Дайрга бутлан ангилах цехийн тоног төхөөрөмжүүдийг төслийн хүчин чадалд үндэслэн 250-450 тн/цаг хүртэлх хүчин чадалтай БНХАУ-ын ^ОУАБ үйлдвэрийн тоног төхөөрөмжүүд ашиглахаар тусгасан. Уг тоног төхөөрөмжүүдээр бутлагдан ангилагдсан дайргыг уурхайн бүтээгдэхүүний ил агуулахын талбайдаа хураахаар төлөвлөсөн байна.

Уг талбай нь бутлан ангилах цехийнхээ дэргэд байршина. Уурхайгаас тэжээж буй барилгын чулууг 3х4 м хэмжээтэй хүлээн авах бункерт хийж түүнийг гулдмай сараалжин шигшүүрт шигшин нэгдүгээр шатны PE 600х900 маркийн хацарт бутлуураар орон Т8\Л/- 1345 маркийн чичиргээт шигшүүрээр шигшигдэх ба түүнээс -20 мм болон +20 мм-ийн дайрга гарах бөгөөд -20 мм-с доошхи ширхэглэлтэй дайрга шууд 3 ангиллын эцсийн бүтээгдэхүүн болон гарна. Харин +20 мм-с дээшхи ширхэглэлтэй дайрга 2-р шатны PE- 1415 маркийн цохилтот бутлуураар орон -20 мм-ээс доош ширхэглэлтэй болон гарах бөгөөд үүнийг дахин шигшүүр лүү өгөн түүнээсээ эцсийн бүтээгдэхүүн болон гарна. Т8\Л/- 1345 маркийн чичиргээт шигшүүрээс гарсан дайрга нь 3 тавцан бүхий ЗҮ2160 маркийн ангилах чичиргээт шигшүүрээр 0-5 мм, 5-10 мм, 10-20 мм ширхэглэлтэй хэсгүүдэд ангилагдана. Уг шат дамжлага бүрт 500-800 мм, 15-22 м хүртэлх урттай туузан конвейроор дамжихаар төлөвлөсөн байна.



Зураг 5. Бутлан ангилах цехийн тоног төхөөрөмжүүдийн холболтын схем зураг

Бутлан ангилах цехийн ажиллах хүч

Бутлан ангилах цехийн ажилчид 2 ээлжээр ажиллах бөгөөд ээлжид инженер 1, тоног төхөөрөмжийн оператор 2, туслах ажилчин 1, цахилгаанчин 1, механик 1, нийт 7 хүн ажиллана. Ажиллах хүчний тооцоог дараах хүснэгтэд харуулав.

Хүснэгт 11. Бутлан ангилах цехийн ажиллах хүчний тооцоо

№	Ажлын байрны нэр	Ээлжид	Хоногт	Нийт
Бутлан ангилах цехийн ажилчид				
1	Баяжуулалтын инженер	1	2	3
2	Тоног төхөөрөмжийн оператор	3	6	9
3	Туслах ажилтан	1	2	3
4	Цахилгаанчин	1	2	3
5	Механикч	1	2	3
	Нийт тоо	7	14	21



Зураг 6. Бутлах ангилах цех

Дэд бүтэц

Барилга, байгууламж:



Зураг 7. Ажилчдын байр

Дулаан хангамж: Сэрүүний улиралд ажиллах цөөн хоногт ажиллагсдын тосгон, уурхайн захиргаа, засварын барилгыг нам даралтын бага оврын зуухаар халаана.

Усан хангамж: 2025 оны уурхайн ашиглалтын жилд ус зарцуулалтын тооцоог хийж үзэхэд нийт технологи, ахуйн хэрэглээнд жилд 3647.0 м^3 хэрэглэхээр тооцогдсон байна.

Үүнд: - Унд ахуйн хэрэглээнд – $624.4 \text{ м}^3/\text{жил}$ /37 хүн*хоногт 80 л нормоор тооцов. Уурхай нь 205 хоног ажиллах бөгөөд засвар үйлчилгээ болон сүл зогсолтын хоног тооцогдсоноор ус ашиглах хугацааг 210 хоногоор тооцлоо./

- Технологийн усны хэрэглээ – (уурхайн замын тоос дарах усны хэмжээ) – $3022.6 \text{ м}^3/\text{жил}$ Уурхайн ундны усыг Мандал сумын төвөөс зөөврөөр, технологийн усыг уурхайн зүүн урд зүгт орших урд өмнө нь ашиглаж байсан Шаврын ордын худгаас хангахаар төлөвлөж гэрээ хэлцэл хийсэн. Уг худгийг “Ачит Хараа” ХХК эзэмшдэг ба худгийн усны ундарга нь 1 л/сек.

Цахилгаан хангамж:

Гадаад цахилгаан хангамж: Эрдэнэтолгойн өвөр барилгын чулууны уурхай нь “Үндэсний цахилгаан дамжуулах сүлжээ”-ний Дархан-Сэлэнгийн салбарын шугамд холбогдох боломжтой. “Дархан-Сэлэнгийн Цахилгаан Түгээх Сүлжээ” ХК-ний Зүүнхараа салбар нь 1967 онд Дархан хотоос Улаанбаатар хотыг холбосон 110 кВа өндөр хүчдэлийн цахилгаан дамжуулах агаарын шугам

ашиглалтад орж Төвийн Эрчим Хүчний Систем бий болсноор үүсгэн байгуулагдсан байна. Зүүнхараа салбар нь одоогоор Сэлэнгэ аймгийн Мандал, Баянгол, Төв аймгийн Сүмбэр сумдын 523 аж ахуйн нэгж, 5900 гаруй ахуйн хэрэглэгчдэд цахилгаан эрчим хүчний түгээлт, хангалтын үйл ажиллагааг явуулж байна.

Эрдэнэтолгойн өвөр барилгын чулууны уурхай нь Зүүнхараа салбарын чиглэлийн 6кВ-ын ЦДАШ-аас 7 км ЦДАШ татаж төслийг эрчим хүчээр хангана.

Дотоод цахилгаан хангамж: Зүүнхараа салбарын чиглэлийн 6кВ-ын ЦДАШ-аас 7 км ЦДАШ татаж уурхай, бутлан ангилах цех болон бусад хэрэглэгчийг цахилгаан эрчим хүчээр хангахаар төсөлд тусгав. Уурхайн үндсэн хэрэглэгч нь: 1. Бутлан ангилах цех 2. Гэрэлтүүлэг 3. Тэсрэх материалын түр агуулах 4. Шатахуун түгээх станц 5. Засварын цех 6. Захиргаа аж ахуй, тосгоны барилга байгууламж гэх мэт Цахилгааны ачаалал нь дараах байдалтай тооцоологдов. Бүрэн чадал: 511.4 кВА 1. Актив чадал: 406.8 кВт 2. Реактив чадал: 310.0 кВАр 3. Уурхайн нийт эрчим хүчний хэрэглээний коэффициент 0.6 4. Жилийн эрчим хүчний хэрэглээ 858348.6 кВтц /Хамгийн их хэрэглээ/ Цахилгаан ачааллын тооцоог үндэслэн ТМ-630/10 маркийн трансформатор сонгосон байна.

ХОЁР. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн үйл ажиллагаанаас агаарын үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Агаарын чанарт дараах хүчин зүйлүүд нөлөөлнө.

- ✓ Хөрс хуулалт, хөрс хуулах, ачих, буулгах болон овоолго хийх үед гарах тоос
- ✓ Тэсэлгээний ажлын үед гарах тоос
- ✓ Хөрс болон дайрга ачих тээвэрлэх үед гарах тоос
- ✓ Машин, механизмаас гарах утаа, хий
- ✓ Тээврийн хэрэгслийн хөдөлгөөнөөр үүсэх тоос зэргээс агаарын чанар хамаарна.
- ✓ Орчны агаар бохирдуулах эх үүсвэр нь дайрга ангилан ялгах технологийн дамжлагын бутлах төхөөрөмжүүд

Усан орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөлөл

Унд, ахуйн зориулалтаар 624.4м^3 , зам талбай, уурхайн тоосжилт дарах зорилгоор 402м^3 нийт 3022.6м^3 усыг гүний худгаас авч ашиглана¹.

Төслөөс усан орчинд үзүүлэх нөлөөлөл нь:

- ✓ Технологийн үйл ажиллагаанд химийн бодис хэрэглэхгүй тул гүний болон гадаргын усны найрлага чанарт нөлөө үзүүлэхгүй ч түлш шатахуун, шатах тослох материалууд зэргээс үүдэн газрын болон газрын доорх ус бохирдох эрсдэлтэй.
- ✓ Мөн ахуйн хатуу болон шингэн хог хаягдлын асуудлаа зөв менежментийн дагуу явуулаагүйгээс болж газрын гадарга болон гүний ус биологийн бохирдолд орох эрсдэлтэй.

Газар болон газрын гадарга, хэвлийд үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Хөрс хуулалт болон уурхайн дэд бүтэц, тосгон болон бутлан ангилах цехийн барилга байгууламж барих, цаашдын ашиглалтын үйл ажиллагаанаас газрын гадаргын төрх байдал алдагдаж, хөрсөн бүрхэвч дарагдах, ухагдах, элэгдэх байдлаар, ургамлан нөмрөг хуулагдах, хөрсөнд дарагдах зэргээр эвдрэлд орно.

Төслийн нутаг дэвсгэр болон түүний эргэн тойрны нутаг дэвсгэр дэх тээврийн хэрэгсэл, хүмүүсийн хөдөлгөөний ихсэлттэй холбоотойгоор хөрсөн бүрхэвч элэгдэн доройтох, ургамлан нөмрөг тоосонд дарагдаж тачир сийрэг болж бүрхэц багасна. Газрын гадарга болон хөрс ахуйн хаягдал, шатах тослох материалаар бохирдох нөлөөлөл бий болж болзошгүй.

Ургамлан нөмрөг, амьтны аймагт үзүүлж болзошгүй гол сөрөг нөлөөлөл

Барилгажилт, дэд бүтэц байгуулах, ил уурхайн үйл ажиллагаагаар хөрс хуулагдах талбайн ургамал нөмрөгт шууд сөрөг нөлөө үзүүлнэ. Мөн үйл ажиллагаагаар үүсэх тоосжилт нь орчны ургамлын ургалт, өсөлт хөгжилтөд болзошгүй сөрөг нөлөө учруулна.

Төслийн үйл ажиллагаанд ашиглагдах техник тоног төхөөрөмжөөс гарах дуу чимээнээс болж хөхтөн, шувуу, жижиг мэрэгч амьтад дайжиж алга болох, мөн хөрс хуулалтын үйл ажиллагаанаас хөрсөн дэх макро, микро бичил амьтад үхэж хорогдох зэрэг нөлөөллүүд үүснэ.

¹ УАТ-2019 Маягт 6.2. Усан хангамж

ГУРАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 12. Байгаль орчинд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар									
1	Тээврийн хэрэгслийн яндангаас утаа болон хорт хий ялгарах	Түлшний чанарын хяналт техникийн хяналт, үзлэг оношилгоог тогтмол тогтоосон хугацаанд хийж байх	Уурхайн бүхий л үйл ажиллагаа	ширхэг	50,000	3	150.0	2025 онд 1 удаа	- Байгаль хамгаалах тухай хууль - Агаарын тухай хууль
2	Эрүүл ахуйн шаардлага хангах, үнэрийн бохирдол тархахаас сэргийлэх	Хогийн цэгийн ойр орчмыг дулааны улиралд ялаа, шавж, бактери үржих, үнэрийн бохирдол тархахаас урьдчилан сэргийлж ариутгал хийж байх,	Хогийн цэг		25,000	2	50.0		- MNS 5013:2009 Бензинээр ажилладаг хөдөлгүүртэй автомашин Утааны найрлага дахь хорт бодисын зөвшөөрөх дээд хэмжээ
3	Ил уурхайн ашиглалтын үйл ажиллагааны үед эвдэгдсэн газруудаас салхи ба техникийн нөлөөгөөр тоос үүсэх	Зам талбайн усалгаа	Уурхайн ухаш	-	-	-	Ус ашиглах гэрээнд тусгасан дүнгээр төлбөр төлнө	Гэрээнд заасан хугацаа бүрд	- MNS 5014:2009 Дизель хөдөлгүүртэй автомашин Утааны тортогжилтын зөвшөөрөх дээд хэмжээ ба хэмжих арга - MNS 4585 :2025 Агаарын чанар, Техникийн ерөнхий шаардлага
Хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөг									
1	Шимт хөрсийг технологийн дагуу хуулна	Шимт хөрсийг стандартын шаардлагын дагуу хадгалж, хамгаалах	Шимт хөрсний овоолго	-			Дотоод төлөвлөлтөөр	2025 он	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5859:2008 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”
2	Шатах тослох материал (ШТМ) асгарсан тохиолдолд орчны хөрсөн бүрхэвчийг	Авто зогсоолыг хатуу хучилттай болгох	Авто зогсоол	-	-		Дотоод төлөвлөлтөөр	2025 он	

ЭРДЭНЭТОЛГОЙН ӨВӨР ХАЙРГА ДАЙРГАНЫ УУРХАЙН 2025 БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал (төгрөг)	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	бохирдуулж болзошгүй								
3	Төслийн үйл ажиллагааны үед үүссэн тоос шороо ургамал дээр унаж хуримтлагдсанаар ургамлын фото синтез явагдах боломжгүй болж, ургамал ургах чадвараа алдах	Тоосжилт дарах усалгаа хийх	Тоос үүсэх бүх орчин	-	-	Агаарын хэсэгт тусгасан	Тоос үүсэх бүрд		
4	Хөрсний бохирдол, талхагдал	Ахуйн хог хаягдлыг ангилан хадгалах, бүрэн бүтэн байдлыг тогтмол хянаж байх	Хогийн цэгийн орчим	-	-	Дотоод төлөвлөлтөөр	2025 онд		MNS 5916:2008 Газар шорооны ажлын үед үржил шимт хөрс хуулалт, хадгалалт
5	Хүн техникийн нөлөөгөөр ургамлан нөмрөг талхлагдах	Ашиглалтгүй талбайн ургамлыг талхлагдлаас хамгаалах	Уурхайн хэмжээнд	Байнга	-	Үйл ажиллагааны зардлаас	БО ажилтан		Хайс хамгаалалт, тэмдэгжүүлэлт хийгдэж, хамгаалагдсан байна
Сөрөг нөлөөг бууруулах нийт зардал						200.0 мян.төг			

ДӨРӨВ. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Техникийн болон биологийн нөхөн сэргээлт

Эрдэнэтолгойн өвөр дайрганы ордын нөөцийн тооцоо, уурхайн ТЭЗҮ-д тусгаснаар 27 жилийн турш уурхайн ашиглалт олборлолт явагдах ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ашиглалт дуусах 24 дэх жилд хийхээр төлөвлөсөн.

Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд **Хараагийн бүсийн сум дундын ойн ангиас** өгсөн саналын дагуу **Хараа голын эрэг дээр** 25 га талбайд 8 жилийн хугацаанд 25000 ширхэг **Бургас** мод тарьж ургуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 13. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал (төгрөг)	Нийт зардал (төгрөг)	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	Тэрбум мод үндэсний хөдөлгөөн	Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд Хараа голын эрэг дээр Бургас мод тарих	ш	1000	5,000	5,000,000	2025 оны 9-10	MNS 6141:2010, MNS 6138:2010, 6258-1:2011
2		Уурхайн тосгонд мод тарих	ш	30	5,000	150,000	2025 оны 10 сард	MNS 5918:2008
Нийт зардал мян.төг						5,150,000		


СЭЛЭНГЭ АЙМАГ
ХАРААГИЙН БҮСИЙН СУМ ДУНДЫН-
ОЙН АНГИ
Сэлэнгэ аймаг, Мандал сум
Утас: 70367077, 93013707

2022-03-29 № 20
Танай 2022-03-29 ны № 03/

"ИТГЭЛТ СТӨВНӨ" ХХК-д:

Танай байгууллагын "Тэр бум мод" тарих үндэсний хөдөлгөөнд нэгдэх хүсэлтийг хүлээн авч, Хараа голын эрэг N48 49 09.36 E106 25 11.85 цэг бүхий хавсралтад заасан нөхөн сэргээх шаардлагатай байгаа 25 га талбайг хуваарилж байна. Дээрх талбайг 1га-д 1000 ширхэг нийт 25000 ширхэг стандартын шаардлага хангасан бургас модны суулгацаар 8 жилийн хугацаанд тарьж ургуулан, арчилан хамгаалах ажиллахыг гүйцэтгэж, Ойн анги-д хийсэн ажлын тайлан мэдээг жил бүр ирүүлж ажиллахыг үүгээр мэдэгдэж байна.

ДАРГА

Р.НАРАН

ТАВ. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах” гэдэг нь төслийн үйл ажиллагаанд өртөгдөн унаган төрх, хэв шинж, амьдрах орчноо алдсан биологийн олон янз байдлыг өөр газарт нөхөн хамгаалах арга хэмжээг хэлнэ.

Сэлэнгэ аймгийн Мандал сумын Шуурхай штабын хүсэлтээр Баянхангайн 6-р багын нутагт байрлах 500 орчим метр үерийн даланг сэргээж хур хогыг хогийн цэгрүү ачиж зайлуулахаар 2,000,000 төгрөгийг төсөвлөсөн.



Зураг 8. Дүйцүүлэн хамгаалах талбайн байршил

ЗУРГАА. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэхүү төслийн үйл ажиллагааны хүрээнд нүүлгэн суурьшуулах ажил хийгдэхгүй.

ДОЛОО. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭ

Уурхайн ашиглалтын талбай орчимд хийгдсэн судалгаагаар ямар нэгэн археологи, палеонтологийн олдвор бүртгэгдээгүй. Гэвч уурхайн газар шорооны ажлын явцад соёл өв олдохыг үгүйсгэж болохгүй. Тиймээс уурхай үйл ажиллагааны явцад соёлын өв олдсон тохиолдолд Соёлын өвийг хамгаалах тухай хуулийн 30.4-т заасны дагуу олдворыг илрүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн дотор сум, дүүргийн бүртгэл мэдээллийн санд заавал бүртгүүлнэ. Хэрэв уурхай ашиглалтын явцад соёлын өв илэрсэн олдсон тохиолдолд уурхайн үйл ажиллагааг түр зогсоон холбогдох мэргэжлийн байгууллагаар авран хамгаалах малтлага судалгааг хийлгэх нь зүйтэй.

Хүснэгт 14. Түүх, соёлын өвийг хамгаалах менежментийн төлөвлөгөө

№	Нөлөөлөлд өртөх түүх, соёлын өв	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
	1	2	3	4	5	6	7	8
1.	Төслийн үйл ажиллагаагаар түүх соёлын өвд үзүүлэх шууд сөрөг нөлөө байхгүй ч болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх шаардлагатай.	Соёлын өвийг хамгаалах тухай МУ-ын хуулийн дагуу газрын хэвлийг ашиглах явцад түүх, соёлын дурсгалт зүйл илэрвэл олборлох ажлаа зогсоож энэ тухай, аймгийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагад нэн даруй мэдэгдэх	Уурхайн орчим	-	Бүтээн байгуулалт, үйл ажиллагаанд нэмэлтээр тусгах		2025 онд	Соёлын өвийг хамгаалах тухай хууль

НАЙМ. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Осол эрсдэлээс хамгаалах ажлын ихэнх нь төслийн үйл ажиллагааны явцад хөдөлмөрийн сахилга бат, хариуцлагын тогтолцоогоор шийдвэрлэгдэх боломжтой бөгөөд цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол, цаашлаад зэрлэг ан амьтдын ослоос урьдчилан сэргийлэх ажилд холбогдох зардал нь төслийн үйл ажиллагааны зардлын санхүүжилтийн хүрээнд шийдвэрлэгдэх боломжтой юм.

Хүснэгт 15. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул, осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Цаг уурын эрсдэлтэй нөхцөлөөс үүсэх гэнэтийн осол	Урьдчилан сэргийлэх мэдээ болон дохиолол холбооны найдвартай байдлуудыг байнга хангах	Төслийн бүх ажилтан, ажиллагсдад хамаарна. Бүх шатны ажиллагсдын ажил үүргийн хуваариар тодорхойлогдсон байна.	Үйл ажиллагааны зардлаар		2025 онд		
2.	Хөдөлмөрийн сахилга бат алдсанаас үүсэх осол	Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, дотоод хяналт, байгууллагын дотоод дүрэм журам мөрдөж, хариуцлагын тогтолцоог бэхжүүлэх						
3.	Шатахууны агуулахын ашиглалтын үед үүсэж болох эрсдэл							
4.	Галын аюулгүй байдал	Гал түймрээс урьдчилан сэргийлэх тоног төхөөрөмж, багаж хэрэгслийн тодорхой цэгүүдэд байрлуулах	Уурхайн хэмжээнд	500.0		2025 онд		
Осол, эрсдэлийн менежментийг хэрэгжүүлэх нийт, мян.төг								500.0

Тэсэлгээний бодис материалын хэмжээ, үзүүлэлтүүд:

2025 онд тэсэлгээ хийгдэхгүй.

ЕС. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 16. Хог хаягдлын менежмент

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Тоо хэмжээ	Нийт зардал, мян.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1.	Ахуйн	- ангилсан хог түр хадгалах цэг тохижуулах	Төслийн ажилчдын кемп, нийтийн эзэмшлийн талбай, ариун цэврийн байгууламж	тн	50,000	30	500.0	7 хоногт 1 удаа	“Хог хаягдлын тухай” хууль, “Энгийн хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагаанд тавигдах ерөнхий шаардлага”, “Хог хаягдлын улсын мэдээллийн нэгдсэн сангийн тогтолцоо, бүрдэл болон мэдээлэл төвлөрүүлэх журам”
2.	Үйлдвэрийн	- Мэдээлэл сурталчилгаа хийх, тэмдэгжүүлэх		-	-	-	-	-	
3.	Аюултай	- Хаягдал зайлуулах гэрээг эрх бүхий этгээдтэй хийх	Аюултай хог хаягдал үүсэх эх үүсвэрүүд	тн	100,000	4	400.0	Улиралд 1 удаа	
4	Түр хадгалах	Хог хаягдлыг ангилан ялгах, түр хадгалах төвлөрсөн цэгийг битүүмжлэн байгуулах	Уурхайн хэмжээнд	шир	Дотоод төлөвлөлтөөр			2025 он	
Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх нийт зардал, мян.төг									900.0

Хог хаягдлын менежментийн цар хүрээ

Баримтлах зарчим. Уурхайн үйл ажиллагааны явцад “Хог хаягдлын менежмент”-боловсруулах нь хэрэгжүүлэх бөгөөд энэ нь дараах зарчмыг баримтална.

Үүнд:

- Хог хаягдлын тухай Үндэсний болон Олон Улсын нийтлэг хууль, журмыг дагаж мөрдөхөд нийцсэн орчин бүрдүүлнэ.
- Хог хаягдлын менежментийн хүрээнд байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаас болон 2019 оны 5 сарын 07-ны өдрийн “Хог хаягдлын менежмент” Үндэсний чуулганаас гаргасан зөвлөмжийг дагаж мөрдөнө.

Хог хаягдлыг ангилах. Уурхайн үйл ажиллагаанаас дараах төрлийн хог хаягдлууд гардаг бөгөөд одоогийн байдлаар “Хог хаягдлын менежмент”-ийн зураг авалт хийж тоо хэмжээг тодорхойлсон зүйлгүй байна. Уурхайн үйл ажиллагаанаас гарах хаягдлыг дараах эрэмбээр ангилна.



Зураг 9. Хог хаягдлын аюулын зэрэглэл, ангилал

Хог хаягдлыг түр хадгалах. Уурхайн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлыг ангилах, өөр дээр түр хадгалахад “Хог хаягдлын тухай” хуульд заасан шаардлагад нийцүүлэх бөгөөд хуулийн 7 дугаар бүлгийн 14 дүгээр зүйлд заасан “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх” болон Засгийн газрын 2018 оны 116 тоот тогтоол, “Аюултай хог хаягдлыг түр хадгалах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах болон бүртгэх, тайлагнах журам”-ын хүрээнд хэрэгжүүлнэ.

Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэх

Хог хаягдлын хэмжээг тодорхойлох. Төслийн үйл ажиллагаанаас хоногт дунджаар 96 кг орчим хог гарна гэж БОННУ-ний “Төслийн товч тодорхойлолт” хэсэгт өгүүлсэн байна. Ажлын зураг авалтаас шалтгаалан шаардлагатай гэж үзвэл зарим цэгүүдэд нэг төрлийн ангиллын савыг хэд хэдээр зэрэгцүүлэн тавьж болно.



Зураг 10. Хаягдал цуглуулах сав

Хог хаягдлыг зайлуулах. Уурхайн үйл ажиллагаанаас хог хаягдлыг зайлуулахад ангилсан нэр төрөл бүрээр холбогдох арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд хог хаягдал хүлээн авах хоёрдогч зах зээлд болон дахин боловсруулагчид, устгал хийх эрх бүхий этгээдүүдтэй тус бүрчлэн гэрээ хийнэ. Энэ ажлыг төслийн үйл ажиллагаа эхлэхэд хамт хэрэгжүүлж эхлэнэ.

Хог хаягдлын ангилал. Уурхайн үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг дээр заасан байдлаар ангилах бөгөөд тэдгээрт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлж уурхайн орчинд хог хаягдлыг ангилах, ангилсан хог хаягдлыг төвөг багатайгаар цуглуулах тухай мэдээллийг үйлчлүүлэгч олон нийтэд мэдээлж

сүрталчлахын зэрэгцээ хогийн цэгүүдийг оновчтой байршуулж холбогдох тэмдэг, тэмдэглэгээг ойлгомжтойгоор хийнэ.

Хүснэгт 17. Төслийн үйл ажиллагаанаас үүсэх хог хаягдлын ангилал

№	Менежментийн ангилал	Уурхайд үүсэх хог хаягдал	Хог хаягдлыг зайлуулах
1	Дахивар хаягдал	хүнсний болон бүх төрлийн шилэн сав, шилэн эдлэл	Дахивар хог хаягдал хүлээн авагчидтай гэрээ хийж хоёрдогч зах зээлд нийлүүлнэ. Гэрээнд ангилсан хог хаягдлын шаардлагад хэрхэн нийцүүлэх тухай асуудлыг тусгана.
		Хөнгөн цагаан, төмөр, метал, зэс, гүүль, тэдгээрээр хийсэн зүйл	
		Элдэв зөөлөн хуванцар, гялгар уут, гялгар баглаа боодол	
		Хувцас, даавуун эдлэл	
		Савхи, резин, мод зэрэг дахин ашиглах боломжит бусад хаягдал	
2	Цаасны хаягдал	сонин, сэтгүүл, дэвтэр	
		бичгийн цаас	
		төрөл бүрийн боодлын цаас, картон	
		сүү, жүүсний тетрапак савлагаа	
3	Хүнсний хаягдал	Нийтийн хоолны үлдэгдэл	Хог хаягдлыг устгах сумын нэгдсэн цэгт нийлүүлэх гэрээ хийж ачилтын хуваарийг тохирно.
		Хүнсний ногоо, жимсний хальс, үлдэгдэл	
		Хэрэглэсэн хүнсний тос	
4	Аюултай хаягдал	Тоног төхөөрөмжийн цэвэрлэгээнээс гарсан арчуур, хаягдал тосны үлдэгдэл	Хог хаягдлын тухай хуулийн 8-р зүйлийн 8.4.3-т заасны дагуу харьяа нутаг дэвсгэрийн эрх бүхий аж ахуй нэгжтэй гэрээгээр зайлуулна.
		Аккумулятор зэрэг ашиглалтаас хаягдаж буй техникийн аюултай хаягдал	
5	Бусад хаягдал	Хэт бохирдсон дахин ашиглах боломжгүй хог хаягдалд: - Нийтийн ариун цэврийн өрөөний хаягдал - Нүхэн жорлон - Уурхайн үйлчилгээний шингэн хаягдал - Мөн ангилаагүй норсон, хэт бохирдсон хаягдлууд орно.	Шингэн хаягдлыг эрх бүхий этгээдтэй гэрээлсний үндсэн дээр соруулж, ангилаагүй бохир хаягдлыг уурхайн хогийн цэгээс Аймгийн нэгдсэн цэг рүү ачуулж зайлуулна. Нүхэн жорлонг ариутгал, устгал хийсний дараа тэнд нь булшилна.
		Барилгын болон тусгаарлах материалаас гарсан дахин ашиглах боломжгүй хог хаягдал; бохирдсон хөрс, шороо, чулуу, элс, хайрга;	Барилгын ажлын үед гарах хог хаягдлыг гүйцэтгэгч компани хариуцан зайлуулах ажлыг гүйцэтгэнэ.
		Дахин ашиглах боломжтой хог хаягдлын ангилалд ороогүй бусад зөвшөөрөгдсөн хог хаягдал	
		Хийн хаягдал: - Хадгалах түлшний ууршилт - Машины ашиглалтаас үүсэх хий	Холбогдох шаардлагуудыг тавьж аюулгүй ажиллагааг хангана.

Хог хаягдлыг зайлуулах хүртэл түр хадгалах нөхцөлийг сайжруулах: Уурхайн үйл ажиллагаанаас гарч байгаа хог хаягдлыг дараах эрэмбээр түр хадгална. Үүнд:

- Үүссэн хог хаягдлыг “Уурхайн хогийн төвлөрсөн цэг”-т хүртэл эх үүсвэр дээр нь цуглуулж маш богино хугацаагаар хадгална. Эх үүсвэр хаягдал цуглуулах ажиллагаа нь нийтийн үйлчилгээний үед хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулах нөхцөлд нийцсэн байна.

- Хог хаягдлыг “Уурхайн хогийн төвлөрсөн цэг” нь ангилсан байдлаар түр хадгалах бөгөөд тэдгээрийг эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэл хадгална.
- Түр хугацаагаар хадгалах “Уурхайн хогийн төвлөрсөн цэг” нь элдэв үнэр гаргахгүй, хог хаягдлыг норгохгүй, хийсгэхгүй байх нөхцөлийг бүрдүүлсэн байна.

Хүснэгт 18. Хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах нөхцөлийг сайжруулах

Нөхцөл	Шаардлага
Эх үүсвэр дээр нь хог хаягдлыг ангилах	• Нийтийн үйлчилгээний зам талбайд хог хаягдлыг цэвэрлэж цуглуулахад ангилах боломжит нөхцөлийг бүрдүүлэхэд хог хаягдлын ангиллын олон улсын нийтлэг жишгийг дагана. • Дахин ашиглахгүй бохир хаягдал, хүнсний хаягдлын түр хадгалалт хугацаа болон эргэлтийн хугацааг хамгийн богино байх шийдлийг боловсруулна. • Нүхэн жорлонг байлгах шаардлагатай бол MNS 5924:2015 “Нүхэн жорлон угаадасны нүх. Техникийн шаардлага”-ын стандартад нийцүүлэн шинэчилнэ. • Аюултай хог хаягдлыг цуглуулах, түр хадгалах, зайлуулах менежментийг тусгайлан боловсруулна. • Ангилсан хог хаягдлыг дахин боловсруулах, устгах, эргэлтэд оруулах нөхцөлөөр нь ялган түс тусахад нь “эрх бүхий этгээд”-д гэрээний үндсэн дээр шилжүүлэн өгнө.
Цуглуулсан хог хаягдлыг зайлуулах	• Уурхайн орчинд элдэв амьтан цуглах, идэш хайх нөхцөлийг бүрэн хааж хог хаягдлыг ил задгай байдлаар хадгалахгүй байх болно. • Нийтийн үйлчилгээний зам талбай ажилчид нарт хог хаягдлын менежментийн шаардлага тавьж, тэдгээрийн орчинд үүссэн хог хаягдлыг “Уурхайн төвлөрсөн хогийн цэгт-” хүлээн авна. • Ажлын байрны хог хаягдлыг эх үүсвэр дээр ангилах нөхцөлийг бүрдүүлж ажиллагсдад “Хог хаягдлын менежмент”-ийг таниулан, ангилсан хог хаягдлыг цэгүүдийн байршлыг зааж, тэмдэгжүүлнэ. • Ангилсан хаягдал бүрийг тусгайлан түр хадгалахад эрх бүхий этгээдэд шилжүүлэх хүртэлх эргэлтийн циклийг тооцно. • Хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, түр хадгалах, зайлуулах явцад ажлын зураг авалт хийж ангилсан нэр төрөл бүрээр тоо хэмжээг тодорхойлно. • Ил задгай хаягдаж байгаа цэгүүдийн байршлыг хугацаа алдахгүй тогтоож шаардлагатай сав бэлдэх, байршуулах, тэмдэгжүүлэх зэрэг арга хэмжээг хурдан шуурхай авна.
Хог хаягдлын боловсролыг дэмжих	• Нийтийн үйлчилгээний цэгээс хог хаягдлыг ангилсан хэлбэрээр цуглуулахад тэмдэгжүүлэлт, мэдээлэл, зар сурталчилгааг оновчтой зөв хэрэглэнэ. • Ил задгай хог хаягдал хаях явдлыг бууруулахад чиглэсэн торгууль шийтгэл оногдуулах, мэдээлэл хүлээн авах, урамшууллын систем бүхий олон нийт рүү чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. • Хог хаягдлын менежментийг хэрэгжүүлэхэд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх үүргийг холбогдох ажилтанд давхар үүрэгжүүлнэ. • Шаардлагатай гэж үзвэл нийтийн үйлчилгээний заал, танхимд ажиглан-туслах, хянан-шаардах арга хэмжээг хэрэгжүүлэх сургагч, ажилтныг тодорхой хугацаагаар ажиллуулна.

АРАВ. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 19. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, төг	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
	1	2	3	4	5	6	7	8
1. АГААРЫН ЧАНАР								
1.	Агаарын чанарын (NO ₂ , SO ₂ , CO, PM _{2.5} , PM ₁₀) дуу шуугианы шинжилгээ хийлгэж байх	Төслийн талбайн эргэн тойронд	Жилд 1 удаа	1	49,500.0+30,000.0 техникч томилолт	79.5	Нэг удаагийн хэмжилтээр 2 ажиглалтыг нэг мөр хийнэ.	- MNS 4585:2025 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага, - MNS 5002:2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй. Шуугианы норм, аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага - MNS ISO 226:2003 Дуу чимээ- хэвийн норм, түвшний хэмжээ
2. ХӨРС, ХӨРСӨН БҮРХЭВЧ								
1	Хөрсний ерөнхий шинжилгээ (Агрохими, Механик бүрэлдэхүүн)	- Талбайн эрүүл хэсгээс	2025 он 9 сар	1	25.0	25.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй.	MNS 3297:2019 Байгаль хамгаалал. Хөрс. Хот, суурин газрын хөрсний эрүүл ахуйн аюулгүйн үзүүлэлт, бохирдлыг үнэлэх MNS 5850:2019 “Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх хэмжээ”,
2	Хөрсний бохирдлын шинжилгээ	- Авто зогсоолын орчим - Хог хаягдлын цэг		1	25.0	50.0		
3	Хөрсний эрүүл ахуй	- Хог хаягдлын цэг - Нүхэн - 00		1	25.0	50.0		
3. УСНЫ ЧАНАР								
1	Усны ерөнхий химийн үзүүлэлтүүд	Ус хэрэглээгээ хангаж буй гүний худаг	2025 онд 1 удаа	1	49.0	49.0	Шинжилгээний үр дүнг мэргэжлийн хөндлөнгийн лаборатори байх нь зүйтэй.	MNS 0900:2018 Хүрээлэн буй орчин. Эрүүл мэндийг хамгаалах. Аюулгүйн байдал. Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага. Чанар, аюулгүй байдлын үнэлгээ,
2	Усны бохирдлын хяналт хийх/ 54 элемент/		2025 онд 1 удаа	1	78.0	78.0		
Хяналт мониторингийг хэрэгжүүлэх жилийн гүйцэтгэлийн зардал, мян.төг								331.5

АРВАН НЭГ. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Үйл ажиллагаандаа технологийн сахилга батыг чанд баримталж, аваар осолгүй ажиллах талаар байнга анхаарал тавихыг уурхайн дарга хариуцан ажиллана. Доорх ажлуудыг компанийн захирал тушаал гаргаж баталгаажуулна.

Хүснэгт 20. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хувиар 2025				Хариуцсан албан тушаалтан	тайлбар
			I улирал	II улирал	III улирал	IV улирал		
1	Мэргэжлийн байгууллагатай хамтран хөдөлмөр хамгаалал, байгаль орчныг хамгаалах, гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг хийх Байгаль орчныг хамгаалах, хог хаягдлаа тогтоосон цэгт хаях, хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны талаар сурталчилгааны самбар гаргаж, шинэчилж байх	200.0			+		Уурхайн дарга	Байгаль хамгаалах тухай хууль Галын аюулгүй байдлын тухай хууль
2	Гал түймэртэй тэмцэх багаж, хэрэгсэл, тоног төхөөрөмж авах, хөдөлмөр хамгаалал, эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээний тоноглолуудыг зохих газарт байнга бэлэн байлгах	200.0			+	+		
	Ажиллагсдыг ажил эхлэхийн өмнө болон ажил дуусах үед эрүүл мэндийг үзлэгт хамруулах, эрүүл мэндийн тандалт судалгаа хийх				+			
3	Галын аюулгүй байдлын дүгнэлтийг дүүргийн Онцгой байдлын хэлтсээр сунгуулах	100.0		+	+			Галын аюулгүй байдлын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1.7 дахь заалт
4	Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь өөрийн өмч, эзэмшил, ашиглалтад байгаа газар болон орчны 50 метр хүртэлх газрын хог хаягдлыг цэвэрлэх, зайлуулах, ногоон байгууламжийн арчилгааг хийх;	-	+					Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3.
5	Ус ашиглуулах дүгнэлт гаргуулах, зөвшөөрөл авах, гэрээ байгуулах						Усны тухай хуулийн 28.4, 28.6, 29.1	
Нийт зардал		500.0						

АРВАН ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛӨЛД ӨРТӨГЧ ОРШИН СУУГЧИД, ОРОЛЦОГЧ ТАЛУУДАД ТАЙЛАГНАХ ХУВААРЬ

Хүснэгт 21. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг тайлагнах хуваарь, зардал

№	Зардлын агуулга	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Хариуцах албан тушаалтан	Холбогдох зардал	Зохион байгуулах газар
1	Аймгийн байгаль орчны газар	Хэвлэмэл болон цахим тайлан	Төлөвлөгөөт ажлын тайлан, биелэлтийн үр дүн, дараа жилийн БОМТ	Жил бүрийн 11 сарын 01-ний дотор	“Итгэлт Стөвнө” ХХК	Үйл ажиллагааны зардлаар	Нутгийн удирдлагын ордон
2	Орон нутгийн удирдлага, хөндлөнгийн хяналт, харьяаллын багийн ИНХ, уурхай орчмын оршин суугчид	Мэдээллийн илтгэл, хэвлэмэл танилцуулга		Жил бүрийн 10 сарын 01-ны дотор			Сумын нутгийн удирдлагын ордон
БОМТ-г тайлагнах ажлын зардлын дүн, мян.төг							-

ТАВ. 2025 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НЭГДСЭН ТӨСӨВ

Д/д	Зардлын утга	Нийт зардал, төг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	200,000
2	Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	5,150,000
3	Дүйцүүлэн хамгааллыг хэрэгжүүлэх зардал	2,000,000
4	Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500,000
5	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	900,000
6	Удирдлага зохион байгуулалтын ажлын зардал	500,000
7	ОХШХ-ийг хэрэгжүүлэх зардал	331,500
8	Нөлөөлөлд өртөгч оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь	-
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардлын дүн		9,581,500

2025 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт **9,581,500** төгрөг зарцуулахаар төлөвлөөд байна.

Хүснэгт 22. 5 жилийн БОМТ хэрэгжүүлэх зардал

Зардлын хэлбэр	2022	2023	2024	2025	2026	Нийт
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний зардал	2,420,0	2,420,0	2,420,0	2,420,0	2,420,0	12,100,0
Хог хаягдлын менежмент	1,000,0	1,000,0	1,000,0	1,000,0	1,000,0	5,000,0
Орон нутагт БОМТ тайлагнах хуваарь	1,000,0	1,000,0	1,000,0	1,000,0	1,000,0	5,000,0
Байгаль орчны аудит хийх- 2 жилд 1 удаа	-	5,000,0	-	5,000,0	-	10,000,0
Газрын төлөв байдлын чанарын улсын баталгаа	3,000,0	-	-	-	-	-
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	1,666,0	1,666,0	1,666,0	1,666,0	1,666,0	8,330,0
Нийт зардал	9,086,0	14,466,0	6,086,0	14,466,0	6,086,0	40,430,0
Нөхөн сэргээлт зардал						152,064,0
Дүйцүүлэн хамгаалах зардал	2,000,0	2,000,0	2,000,0	2,000,0	2,000,0	10,000,0
Бүгд: 5 жилд						192,394,0

5 жилийн БОМТ-ний зардал 192,394 мян.төг боловч Эрдэнэтолгойн өвөр дайрганы ордын нөөцийн тооцоо, уурхайн ТЭЗҮ-д тусгаснаар 27 жилийн турш уурхайн ашиглалт олборлолт явагдах ба техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлыг уурхайн ашиглалт дуусах 24 дэх жилд хийхээр төлөвлөсөн байгаа нь эхний 5 жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нөхөн сэргээлтээр хийгдэх ажил тусгагдахгүй. Иймд 5 жилийн БОМТ-ний зардал 50,430 мян.төг байна.